



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 24 өдөр

Дугаар 1183

Шивээговь сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.1.1, 7 дугаар зүйлийн 7.3, 8 дугаар зүйлийн 8.1, 8.3, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр “Босго үнэ шинэчлэн батлах тухай” тогтоол, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн “Сумын 2021 оны төсөв батлах тухай” 09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2021 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Шууд худалдан авалтын ажлын гүйцэтгэгч, нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

(Засаг даргын Тамгын газрын дарга)

Нарийн бичгийн дарга:

(Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд:

(Ашиглагч байгууллагын төлөөлөл)
(Төрийн байгууллагын төлөөлөл)
(Иргэний төлөөлөл)

2. Худалдан авах ажлыг захиалагчаас гаргасан ажлын даалгаврын дагуу шаардлагад нийцсэн гүйцэтгэгч, нийлүүлэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг /Ажлын хэсгийн дарга/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

П.ГАНЧИМЭГ

